

★ Сэтгэлийн авишиг хүртээх нь Үнэндээ сэтгэлийн авишиг биш ... Та нарын энд ирсэн чинь зөвхөн надаар дэмжүүлэх төдий юм. Би шавь элсэхийн төлөө энд ирсэн биш ... харин танд тусалж таныг багш болгохын төлөө ирсэн юм.

—Suma Ching Hai—

★ Яаж сэм завилал хийхийг олноороо мэдэж байвч та нар буруу завилал хийдэг. Зарим нь сэм завилал хийхдээ гоо хүнийг санаж, зарим нь мөнгө олохыг дурлаж, зарим нь наймаа хийхээ бодож байна. Та нар бүх оюунаа төвлөрүүлэн ганц зориг, нэгэн сэтгэлээр ямар нэгэн явдлыг сэтгэдэг л юм бол тэр чинь сэм завилал мөн. Өөрийнхөө анхаарлыг дотоод дахь хүчин зүгээ хандуулан, хурмастын энэрэл, хайр, нигүүлсэнгүй зан чанар зүг хандуулна.

—Suma Ching Hai—

★ Авишиг хүртсэн нь нэгэн шинэ дэс давхаргад шилжин ороод шинэ амьдрал эхэлснийг илтгэж байна. Авишиг хүртсэн нь багш таныг богдчуудын бүлгэмийн нэгэн бүрэлдэхүүн болгож элссэнийг илтгэж байна. Та нэгэнт эгэл хүн биш болж дэс чинь дээшилжээ. Эрт Үед Үүнийг " угаалга хүртсэн" гэх буюу бурхныг " сахилтан дагасан" гэдэг.

—Suma Ching Hai—

СЭТГЭЛИЙН АВИШИГ— АРЯВАЛЫН НОМЫН ЦОГЦОС

Suma Ching Nai сэтгэлийн авишгаар дамжин, Арявалын номын цогцсыг Үнэн сүсгээр бясалгаж, Үнэн ёсыг хүсдэг хүмүүст уламжилна. " Дуу сонсох " гэдэг нь хятад хэлний утгаар амарлингуй сууж авианы дуурсахуйг ажиглан сонсох явдал болно. Энэхүү номын цогцост дотоодын " гэрэл " ба " дуун " — ыг ажигалх явдал болно. Эртнээс аваад дэлхийн буй бүхий шашин суртахуун жич бясалгалын ном сударт цөм энэхүү зүйлийн дотоодын ойлголтыг дахин давтан дурдсан байдаг.

Тухайлбал Христийн Библийн номд:
" Түмэн бодис уг нь дуун аялгуунаас

эхэлсэн юм. Энэхүү дуун аялгуу хаан хурмасттай хамт оршино. Энэхүү дуун аялгуу бол хаан хурмаст мөн" гэжээ. (Иоганы буяны дуурсалын 1 - р бүлгийн 1 - р хэсэг) Энэхүү дуун аялгуу бол дотоодын дуун аялгууг зааж байдаг. Өөрөөр хэлбэл "хаан хурмастын хэл", "shabd", "ном", "аялгууны урсгал", "ум" эсхүүл "тэнгэр дээрх хөгжим" гэж бас хэлдэг. Suma Ching Hai хэлсэн нь: "Тэр бол түмэн бодисын дотор долгиолон хэлбэлзэж байх бөгөөд бүх орчлонг ивээн дэгжрүүлж байна. Энэхүү дотоодын аялгуу бол буй бүхий гэмтлийг эмнэн эдгээж, буй бүхий хүсэл эрмэлзэлийг хангаж, аливаа зан дадгалын хүсэл мөрөөдлийг амаржуулж чадна. Тэр бол төгс чадвартан бөгөөд асрахуйгаар төгөлдөр юм. Бид энэхүү дуун аялгуунаас Үүссэн учраас түүнтэй

нэвтрэлцвэл сэтгэлийн амарлингуйг авчирч өгөх ба хангамжтай болгоно. Энэхүү дуун аялгууг сонссоны дараа бидний бүхий л биед хувиралт гарч, бидний амь насны тухай ухагдахуун ихээр дээшлэх болно" гэжээ.

"Билэг нээгдэх" гэдэг энэ үг бол дотоодын гэрэл — хаан хурмастын гэрлийг зааж байна. Түүний хүчилц нь өчүүхэн гэрлээсээ тоо томшгүй наран мэт гэрэлтүүлдэг. Дотоодын гэрэл ба аялгуугаар дамжаад бид хаан хурмастыг таньж мэддэг юм.

Арявалын номын цогцсыг бясалгах, сэтгэлийн авишиг хийх нь тийм нууц ёслол буюу шинэ суртахуунд орох явдал биш. Сэтгэлийн авишиг хийх үед сэм завилал хийх — гэрэл үзэх ба дуун сонсохын онц анхаарах зүйлийг зааварладаг. Анхдугаар ариун ойлголт нь

нам жим байтал морилон ирэх болно. Сэтгэлийн авишгийг уламжилах нь энэхүү номын цогцсын охь болно. Suma Ching Hai өөрийн биеэр тухайн газарт нь ирж, танд энэ үүдийг нээж өгөх чухалгүй, гэвч багшийн ач энэрэл байхгүй бол эдгээр арга чаргын тус бие нь ямар ч ач тус олгож чадахгүй юм.

Сэтгэлийн авишиг хийх үед та тэр дотоодын аялгууг сонсох бөгөөд дотоодын гэрлийг олж үздэг, ийм байдлыг "агшнаа онож мэдэх" буюу "агшин зуур билэг нээгдэх" хэж хэлж болох юм.

Suma Ching Hai аливаа шашнуудын бүлэгтэн ба адил бус орчин байдалтай хүмүүс ирж сэтгэлийн авишиг хийгийг хүлээн авна. Та угийн шашин суртахуун буюу сүсэг бишрэлээ хувируулах хэрэггүй. Таныг ямар нэгэн зохион байгуулалтад оруулахаар шаардахгүй,

таны одоохь амьдралын арга маягт Үл тохирох ямар нэгэн ажиллагаанд ор гэж шаардахгүй.

Гэвч бацаг барих явдал бол зайлшгүй чухал. Насаараа бацаг барих нь сэтгэлийн авишгийг хүлээн авахад эрхбиш хүлээн авах нөхцөл мөн.

Сэтгэлийн авишигт ямар ч зүйлийн төлбөр авахгүй.

Өдөр бүр сэм завилж Арявалын номын цогцсыг бясалгах, таван санваарыг сахих нь сэтгэлийн авишиг хийсний дараахь цорын ганц шаардлага болно. Сахил санваар бол нэгэн зүйлийн норм болно. Таныг тусалж өөрийн биеэ хорлохгүй, бусад амьтныг хорлохгүй болгоно. Бясалгал хийвэл сэтгэлийн авишиг хийх үеийн билэг нээгдэх ауи ойлголтоо гүнзгийрүүлэх бөгөөд ивээж чадах болно. Эцэстээ хамаг өндөр

ухамсрыг олох буюу бурхан болох юм. Хэрэв өдөр бүр бясалгал хийхгүй бол өөрийн нэгэнт билэг нээгдсэнээ мартаж, энгийн үзэл ухамсрын давхаргадаа буцах юм.

Suma Ching Hai – н зорилт бол бидний өөрийн мөрийг бүтээхийг сургахад оршино. Иймээс түүний сургаж байх номын цогцсыг хүн бүр бясалгаж болох юм. Өөрөө бясалгаж болно. Ямар нэгэн гаднах тусламжийг түших хэрэггүй. Чинхай багш мөргөлчин, шүтэгч, шавь эрдэггүй, зохион байгуулалт байгуулж татвар хураахгүй, таны мөнгө зоос, өргөл барьц, мөргөлийг хүлээн авахгүй, та түүнд тахил өргөх хэрэггүй.

Ганцхан таны Үнэн сүсэг — өдөр бүрийн амьдралдаа сэм завилан бясалгал хийж, өөрийгөө дээшлүүлж, богд

эрдэмтэн болох тэрхүү Үнэн сүсгийг
чинь хүлээн авна.

ТАВАН САХИЛ

(1) Амь хороогүй (Бүрмөсөн бацаг барьж, сүү ба сүүгээр хийсэн идээнийг идэх болох).

(2) Худал хэлэхгүй.

(3) Хулгай хийхгүй.

(4) Садар самуун явахгүй.

(5) Архи уухгүй (Хорт бодис хэрэглэхгүй, санаа сэтгэлийг хөгсөөх элдвийн ном сониныг үзэхгүй).

★ Багшийн хайр миний сүнсийг
гийгүүлснээ

Бас нэг шинэ амиллыг агшнаа
хүртээгээд

Шалтгаан юу болохыг би эс ойлгосон

Гэвч шалтгаан нь богдын хайрын
логик биш

Би бол орчлонгийн ам хэл
Илээр их л хашгараад
Түмэн бодисыг орлож уйтгар
гунигийг нь ярьсан

Төрж үхэх сансрын хурдыг багш
ирээд зогсоожээ.

Адислалаа та дорогш хөнтрөөд
Сайн муу хүнийг ялгалгүй
Гоо муухай гэж үл ялгаж
Үнэн сэтгэлтэн ба бүтэлгүй этгээд
гэж эс хуваарилан

Аа! Багшаа! Яаж магтах үг олдохгүй
Богдын хайрыг чинь тэврээд миний
сэтгэл дээр

Үдэш бүр хамт нойрсож буй.

Suma Ching Hai—н Дуугүй нулимс
гэдэг шүлгийн түүврээс авав.